

КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН
ҮНЭЛГЭЭ

/СУДАЛГААНЫ ТАЙЛАН/

ЗАХИАЛАГЧ: ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

СУДАЛГААГ ГҮЙЦЭТГЭСЭН: ХУУЛЬЧ, СУДЛААЧ З.Уянга

Улаанбаатар хот

2024 он

АГУУЛГА

ТОВЧЛОЛ	2
УДИРТГАЛ	3
НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	4
1.1 Үнэлгээ хийх шалтгаан	4
1.2 Үнэлгээ хийх хүрээ	5
1.3 Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт	6
1.4 Үнэлгээний харьцуулах хэлбэр	7
1.5 Шалгуур үзүүлэлтийг томъёолох	7
1.6 Мэдээлэл цуглуулах аргыг сонгох	8
ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ	9
ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ	11
3.1 Компанийн жижиг хувьцаа эзэмшигчийн эрх ашгийн талаарх зохицуулалт	12
3.2 Мөнгөн бус хөрөнгө оруулалт	16
3.3 Үүсгэн байгуулагчийн хуралтай холбоотой зохицуулалт	18
3.4 Үүсгэн байгуулах үеийн гэрээ хэлцэл, эрх бүхий албан тушаалтны бүрэн эрх	22
3.5 Компанийн нөөц хөрөнгөтэй холбоотой зохицуулалт	24
3.6 Ногдол ашиг хуваарилахтай холбоотой зохицуулалт	26
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	32
ЭХ СУРВАЛЖ	35

ТОВЧЛОЛ

ААН	Аж ажуйн нэгж
ЗГ	Засгийн газар
КтХ	Компанийн тухай хууль
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХЗҮХ	Хууль зүйн үндэсний хүрээлэн
УБ	Улаанбаатар
УИХ	Улсын Их Хурал

УДИРТГАЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу Компанийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу тус үнэлгээг хийв.

Энэхүү ажлын зорилго нь хуулийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгахын зэрэгцээ хуулийг хэрэгжүүлснээр гарч буй хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг байдлыг илрүүлэн, тодорхой шалгуур үзүүлэлтэд үндэслэн дүгнэлт гаргах, цаашид зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлж, зөвлөмж боловсруулахад оршино.

Хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажил нь төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн үндсэн гурван үе шатаас бүрдсэн болно

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Төлөвлөх үе шатны зорилго нь үнэлгээ хийх хүрээг тогтоож, түүнд тохирсон шалгуур үзүүлэлтийг тодорхойлоход чиглэнэ. Энэ үе шатанд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- 1) Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
- 2) Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
- 3) Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
- 4) Харьцуулах хэлбэрийг сонгох;
- 5) Шалгуур үзүүлэлтийг томьёолох;
- 6) Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.

1.1 Үнэлгээ хийх шалтгаан

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалд заасны дагуу хууль тогтоомж нь тухайн харилцааг зохицуулж чадаж байгаа эсэх болон тухайн хууль тогтоомжийн нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэхийн тулд үнэлгээний ажлыг эхлэхээс өмнө үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлно.

Компани үүсгэн байгуулах, бүртгүүлэх, өөрчлөн байгуулах, компанийн удирдлага, зохион байгуулалт, хяналтын бүтэц, хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийг тогтоох, компани татан буулгахтай холбогдсон харилцааг 2011 онд батлагдсан Компанийн тухай хуулиар зохицуулж байна. 2020 онд Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс “Компанийн эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал, тулгамдсан асуудал” судалгааг гүйцэтгэсэн бөгөөд тус судалгаагаар Компанийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг сонгон авч хэрэгжилтэд тулгарч буй асуудлыг үнэлсэн байдаг. Өөрөөр хэлбэл, тус судалгаагаар хөндөгдөөгүй бусад зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх зайлшгүй шаардлага байна гэж үзэв.

Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 51.3 дахь хэсэгт “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно” гэж заасны дагуу

Компанийн тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлж, тулгамдаж буй асуудлыг тодорхойлохыг зорилоо.

1.2 Үнэлгээ хийх хүрээ

Үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэдэг.

Тус хуулийн 51.4 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн зохицуулах харилцааны онцлог, асуудлаас хамааран хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийхдээ хууль тогтоомжид бүхэлд нь, эсхүл түүний зарим зүйл, хэсэг, заалтыг сонгож болно” гэж заасны дагуу Компанийн тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлсэн болно.

Ингэхдээ үнэлгээ хийх болсон шалтгаануудтай харилцан уялдаа, хамааралтай байдлыг харгалзаж, хуулийн хэрэгжилтэд гарч буй эерэг, сөрөг нөхцөл байдал, хүндрэл бэрхшээл, тулгамдсан асуудал, үр дагавар бүхий харилцаатай холбогдсон зохицуулалтыг сонгох учиртай.

Компанийн эрх зүйн онол, практикийг хөндсөн эрдэмтдийн бүтээл, хууль тогтоомжийн хэрэгжилтийг судалсан ажлын тайлан, эрдэм шинжилгээний бага хурал, хэлэлцүүлэг зэрэг олон нийтийн зөвлөлдөх ажиллагааны үр дүн, илтгэл, нийтлэл зэрэг эх сурвалжийг судалж, үнэлгээ хийх хүрээг тогтоов.

Үүний үр дүнд Компанийн тухай хуулийн дараах зохицуулалтыг үнэлгээ хийх хүрээнд хамруулав. Үүнд:

№	Үнэлгээ хийх хуулийн зүйл, заалт	Зохицуулалтын агуулга
1	Компанийн тухай хуулийн 84.7 дахь хэсэг болон 84.10 дахь хэсэг	Компанийн жижиг хувьцаа эзэмшигчийн эрх ашгийн талаарх зохицуулалт

2	Компанийн тухай хуулийн 30 дугаар зүйл, 14.7 дахь хэсэг	Мөнгөн бус хөрөнгө оруулалт
3	Компанийн тухай хуулийн 14 дүгээр зүйл	Үүсгэн байгуулагчийн хуралтай холбоотой зохицуулалт
4	Компанийн тухай хуулийн 12 дугаар зүйл	Үүсгэн байгуулах үеийн гэрээ хэлцэл, эрх бүхий албан тушаалтны бүрэн эрх
5	Компанийн тухай хуулийн 46.8, 47.4 дэх хэсэг	Компанийн нөөц хөрөнгөтэй холбоотой зохицуулалт
6	Компанийн тухай хуулийн 46, 47 дугаар зүйл	Ногдол ашиг хуваарилахтай холбоотой зохицуулалт

1.3 Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт

Аргачлалын 3 дугаар зүйлийн 3.4-т Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг тодорхойлоход сонгох шалгуур үзүүлэлтүүдийн жагсаалтыг тусгасан. Үнэлгээ хийх асуудал тодорхой болсон үед тодорхой 1 шалгуур үзүүлэлтийг сонгон авах бөгөөд зөвхөн 1 шалгуур үзүүлэлтээр тухайн асуудалд бүрэн үнэлэлт өгөх боломжгүй тохиолдолд 2 болон түүнээс дээш шалгуур үзүүлэлтийг сонгох боломжтой.

Аргачлалд дурдсан шалгуур үзүүлэлтээс уг аргачлалын 3.4.1-д заасан “зорилгод хүрсэн түвшин” болон 3.4.5-д заасан “практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийг сонгов. Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд, тухайн зохицуулалтын хэрэгжилт, түүний эерэг, сөрөг үр дагавар болон хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл гарч байгаа эсэхийг тодорхойлно.

“Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтээр тухайн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэхийг тогтоох бол, “практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтээр тухайн хууль тогтоомжийн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэхийг тодорхойлно.

1.4 Үнэлгээний харьцуулах хэлбэр

Хууль тогтоомж хэрэгжсэнээр нийгмийн харилцаанд гарсан эерэг, сөрөг өөрчлөлтүүдийг олж тодорхойлоход харьцуулах хэлбэрүүдийг ашигладаг. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын 3.5.3-т заасан дөрвөн төрлийн харьцуулах хэлбэрээс 3.5.3.4-т заасан “тохиолдол судлах”¹ хэлбэрийг сонголоо.

Тохиолдол судлах хэлбэрийн хүрээнд хууль тогтоомж (түүний зүйл, хэсэг, заалт), эсхүл үнэлгээний хүрээгээр тогтоосон ижил төстэй эрх зүйн хэм хэмжээ өөр өөр орчин нөхцөлд (бусад улсад, өөр орон нутагт гэх мэт) хэрэгжиж байгаа байдлыг харьцуулан дүн шинжилгээ хийнэ. Ийнхүү бусад улсын хууль тогтоомжийг харьцуулж судлах нь Компанийн тухай хуулийг боловсронгуй болгох ажлын хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай гэж үзэв. Гэхдээ манай улсын тэргүүлэх эрдэмтэн судлаачдын судалгааны үр дүнд тодорхой болсон асуудлын хувьд “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын “Хэрэв шалгуур үзүүлэлтийг томьёолох явцад асуудал тодорхой болсон тохиолдолд цаашид түүгээр мэдээлэл цуглуулах шаардлагагүй. Харин үнэлгээндээ асуудал тодорхой болсныг үндэслэлтэй тайлбарлана.” гэсэн арга зүйг баримталсан.

1.5 Шалгуур үзүүлэлтийг томьёолох

Энэхүү үнэлгээг хийхдээ Аргачлалын “зорилгод нийцсэн байдал”, “практикт нийцэж байгаа байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгож авсан. Эдгээр шалгуур үзүүлэлтийг томьёолж, дараах асуултыг боловсруулав. Үүнд:

- Компанийн тухай хуулийн 84.7 дахь хэсэг болон 84.10 дахь хэсэг нь зорилгодоо нийцэж байгаа эсэх, практикт хүндрэл, бэрхшээл учруулж байгаа эсэх;

¹ Хууль тогтоомж (түүний зүйл, хэсэг, заалт), эсхүл үнэлгээний хүрээгээр тогтоосон ижил төстэй эрх зүйн хэм хэмжээ өөр өөр орчин нөхцөл (бусад улсад, өөр орон нутагт гэх мэт)-д хэрэгжиж байгаа байдлыг харьцуулан дүн шинжилгээ хийхийг хэлнэ.

- Компанийн тухай хуулийн 30 дугаар зүйл, 14.7 дахь хэсэг нь зорилгодоо нийцэж байгаа эсэх, практикт хүндрэл, бэрхшээл учруулж байгаа эсэх;
- Компанийн тухай хуулийн 14 дүгээр зүйл нь зорилгодоо нийцэж байгаа эсэх, практикт хүндрэл, бэрхшээл учруулж байгаа эсэх;
- Компанийн тухай хуулийн 12 дугаар зүйл нь зорилгодоо нийцэж байгаа эсэх, практикт хүндрэл, бэрхшээл учруулж байгаа эсэх;
- Компанийн тухай хуулийн 46.8, 47.4 дэх хэсэг нь зорилгодоо нийцэж байгаа эсэх, практикт хүндрэл, бэрхшээл учруулж байгаа эсэх;
- Компанийн тухай хуулийн 46, 47 дугаар зүйл нь зорилгодоо нийцэж байгаа эсэх, практикт хүндрэл, бэрхшээл учруулж байгаа эсэх.

1.6.Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Энэхүү судалгааны ажлын хүрээнд үнэлгээ хийх хуулийн зүйл, заалтын зорилгод хүрсэн түвшин, практик хэрэгжилтийг илрүүлэх зорилгоор бодлогын баримт бичиг, эрдэм шинжилгээ, судалгааны эх сурвалжууд уншиж судлах, харьцуулалт хийх аргаар хэрэгцээтэй мэдээлэл олж авсан. Мэдээлэл цуглуулах дараах аргыг ашигласан болно. Үүнд:

- Аргачлалын 3.7.3.1-д заасны дагуу “Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах” хүрээнд: Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Компанийн тухай хууль, холбогдох хууль тогтоомж болон бусад баримт бичиг, ном, гарын авлага, эрдэм шинжилгээ, судалгааны тайлан, өгүүлэл, статистикийн тоо баримт цуглуулж, дүн шинжилгээ хийсэн болно

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Компанийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ холбогдох сэдвийг хөндсөн эх сурвалжийг судалж, мэдээлэл цуглуулсан.

Тухайлбал:

- Хууль зүйн ухааны доктор, профессор Б.Амарсанаа “Компанийн засаглал, Компанийн эрх зүйн тулгамдсан асуудал”,
- ”Хууль зүйн ухааны доктор Г.Давааням “Компанийн эрх зүйн онол, практик”, “Компани, арилжааны эрх зүйн тулгамдсан асуудал”, “Хувьцаат компанийн эрх зүйн үндсэн ойлголт”, “Морал хазардын асуудлаас үүдэх толгой компанийн хариуцлага” зэрэг бүтээл,
- Хууль зүйн ухааны доктор, профессор Б.Амарсанаа, Г.Давааням нарын “Арилжааны эрх зүй” бүтээл;
- Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн гүйцэтгэсэн 2020 оны “Компанийн эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал, тулгамдсан асуудал” сэдэвт судалгааны тайлан ,
- 2022 оны “2011 оны Компанийн тухай хууль дахь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ” сэдэвт судалгааны тайлан,
- 2019 оны “Компанийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ” сэдэвт судалгааны тайлан,
- 2013 оны “Компани худалдан авах, өөрчлөн байгуулах үндсэн аргууд: гадаад орнуудын туршлага” сэдэвт судалгааны тайлан хамаарна.

Дээр дурдсанаас гадна дараах эх сурвалжийг мөн судалж ашиглав. Үүнд:

- **Хууль тогтоомж:**
 - Иргэний хууль.
 - Компанийн тухай хууль
 - Үнэт цаасны зах зээлийн тухай хууль
 - Даатгалын тухай хууль
 - Банкны тухай хууль.
 - Хөрөнгийн үнэлгээний тухай хууль.

- Оюуны өмчийн тухай хууль.
- Хөрөнгө оруулалтын тухай хууль

➤ **Ном, сурах бичиг, эмхэтгэл:**

- Д.Байлхүү, “Төлөөлөн удирдах зөвлөл”, УБ, Адмон, 2016 он.
- Д.Байлхүү, “Хувьцаа эзэмшигчдийн хурал”, УБ, Адмон, 2016 он.
- Д.Байлхүү, Г.Давааням, “Компанийн тухай хуулийн тайлбар”, УБ, 2023 он.

- **Судалгааны тайлан, эрдэм шинжилгээний өгүүлэл:**

- А.Бодьбилэг, Хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хурлын талаар гомдол гаргах эрх болон түүний хязгаарлалт: Харьцуулсан судалгаа, 2022 он.
- ХЗҮХ, Хязгаарлагдмал хариуцлагыг нэвтрэх нь. Толгой болон охин компанийн хариуцлагын асуудал, 2010.
- Ц.Золбоо, Хувьцаат компанийн эзэн ба агентын асуудал, түүнийг зохицуулах стратегиуд, Эрх зүй сэтгүүл №1, 2021.

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Үнэлэх үе шатанд аргачлалын “зорилгод нийцсэн байдал”, “практикт хэрэгжиж буй байдал” шалгуур үзүүлэлтийн томъёоллын дагуу Компанийн тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийг үнэллээ.

Хэрэгжилтийн үе шатанд цуглуулж, уншиж судалсан эх сурвалжид тусгагдсан мэдээлэлд үндэслэж, Компанийн тухай хуулийн боловсронгуй болгох шаардлагатай, зарим зүйл, заалт, хэрэгжилтэд тулгамдсан асуудлыг хөндлөө.

Ингэхдээ шалгуур үзүүлэлтийг томъёолох үе шатанд боловсруулсан дараах томъёоллын агуулгад нийцүүлж дэд бүлгийг нэрлэсэн болно. Үүнд:

№	Шалгуур үзүүлэлтийн томъёолол	Дэд бүлгийн гарчиг
1	Компанийн тухай хуулийн 84.7 дахь хэсэг болон 84.10 дахь хэсэг нь зорилгодоо нийцэж байгаа эсэх, практикт хүндрэл, бэрхшээл учруулж байгаа эсэх;	Компанийн жижиг хувьцаа эзэмшигчийн эрх ашгийн талаарх зохицуулалт
2	Компанийн тухай хуулийн 30 дугаар зүйл, 14.7 дахь хэсэг нь зорилгодоо нийцэж байгаа эсэх, практикт хүндрэл, бэрхшээл учруулж байгаа эсэх;	Мөнгөн бус хөрөнгө оруулалт
3	Компанийн тухай хуулийн 14 дүгээр зүйл нь зорилгодоо нийцэж байгаа эсэх, практикт хүндрэл, бэрхшээл учруулж байгаа эсэх;	Үүсгэн байгуулагчийн хуралтай холбоотой зохицуулалт
4	Компанийн тухай хуулийн 12 дугаар зүйл нь зорилгодоо нийцэж байгаа эсэх, практикт хүндрэл, бэрхшээл учруулж байгаа эсэх;	Үүсгэн байгуулах үеийн гэрээ хэлцэл, эрх бүхий албан тушаалтны бүрэн эрх
5	Компанийн тухай хуулийн 46.8, 47.4 дэх хэсэг нь зорилгодоо нийцэж байгаа эсэх, практикт хүндрэл, бэрхшээл учруулж байгаа эсэх;	Компанийн нөөц хөрөнгөтэй холбоотой зохицуулалт

6	Компанийн тухай хуулийн 46, 47 дугаар зүйл нь зорилгодоо нийцэж байгаа эсэх, практикт хүндрэл, бэрхшээл учруулж байгаа эсэх.	Ногдол ашиг хуваарилахтай холбоотой зохицуулалт
---	--	---

3.1 Компанийн жижиг хувьцаа эзэмшигчийн эрх ашгийн талаарх зохицуулалт

Компанийн хувьцаа нэг буюу нэгдмэл сонирхолтой этгээдүүд хэт төвлөрснөөс үүдэн компанийн менежментийн бодлого доголдож, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг боогдоход хүрдэг.

Улмаар тухайн хувьцааны хөрвөх чадвар муудан, зах зээлийн үнэ цэнээ алдахад хүрдэг байна.²

Нэгдмэл сонирхолтой этгээдүүд компанийн хувьцааны дийлэнхийг эзэмшиж, цаашлаад өөрсдөө удирдах эсхүл өөрсдийн ойр дотны хүмүүсийг удирдах албан тушаалд томилох, мөн түүнчлэн жижиг хувьцаа эзэмшигчдийн санал бодлыг авч хэлэлцэхгүй байх үзэгдэл практикт цөөнгүй. Тухайлбал, 2022 оны байдлаар ТОП-100 аж ахуйн нэгжийн 91 нь хязгаарлагдмал хариуцлагатай компани, 9 нь хувьцаат компани байна. Компанийн засаглалын хувьд тавигдах хуулийн шаардлага нь нээлттэй хувьцаат компани руу түлхүү чиглэдэг.

Гэвч Компанийн засаглалын кодекст³ заасан компанийн засаглалын зарчмыг үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад үнэт цаас гаргагч, даатгагч, итгэлцлийн үйлчилгээ болон хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхэлдэг хязгаарлагдмал хариуцлагатай компани заавал дагаж мөрдөх үүрэгтэй байдаг.

Дээрхээс бусад компани нь КтХ болон бусад эрх зүйн актад заасан зарчмыг өөрсдийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх эсэх нь чөлөөтэй. Энэ төрлийн компанид жижиг хувьцаа эзэмшигчид рүү чиглэсэн мэдээллийн ил тод байдал сул. Өөрөөр хэлбэл, хууль тогтоомжид заасан жижиг хувьцаа эзэмшигчийг хамгаалах ихэнх зохицуулалт хэрэгждэггүй. Иймд жижиг хувьцаа эзэмшигч компанийн болон

² Ким Сын Квон, Хувь нийлүүлэгчийн эрх ашгийг дээдэлснээр компанийнхаа үнэ цэнийг өсгөж чадна,

³ Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 03 сарын 23-ны өдрийн 145 тогтоолоор шинэчлэгдсэн хувилбар.

компани дахь өөрийн эрх ашгийг хамгаалах зохицуулалт нь дериватив нэхэмжлэл буюу төлөөлөн нэхэмжлэл гаргах хувьцаа эзэмшигчийн эрх юм.

КтХ-ийн 84.7 дахь хэсэгт “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага нь энэ хуулийн 84.4-т заасан үүргээ биелүүлээгүй бол компанийн хувьцаа эзэмшигч уг албан тушаалтнаар компанид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.” гэж, мөн хуулийн 84.10 дахь хэсэгт “Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн нийт гаргасан хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшдэг этгээд нь энэ хуулийн 84 дүгээр зүйлд заасан хариуцлагыг эрх бүхий албан тушаалтны нэгэн адил хүлээнэ.” гэж, 86.1 дэх хэсэгт “Компанийн энгийн хувьцааны нэг буюу түүнээс дээш хувийг эзэмшигч нь компанид учруулсан хохирлыг компанийн эрх бүхий албан тушаалтнаар нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.”, 86.2 дахь хэсэгт “Компани болон түүний энгийн хувьцааны нэг буюу түүнээс дээш хувийг эзэмшигч нь компанид учирсан хохирлыг энэ хуулийн 84.10-т заасан этгээдээр нөхөн төлүүлэхээр энэ хуульд заасан журмын дагуу шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.” гэж тус тус хуульчилсан.

Дээрх зохицуулалт нь компанид хохирол учруулсан төлөөлөн удирдах зөвлөл, эрх бүхий албан тушаалтан, цаашлаад компанийн нийт гаргасан хувьцааны 20 ба түүнээс дээш хувийг эзэмшдэг хувьцаа эзэмшигчийн эсрэг бусад хувьцаа эзэмшигч (нэгээс дээш хувьцаа эзэмшдэг хувьцаа эзэмшигч) шүүхэд нэхэмжлэл гаргах эрх зүйн үндэслэл юм. Дээр дурдсан хувьцаа эзэмшигчийн нэхэмжлэл гаргах эрх зохицуулалтууд нь хоорондоо харилцан ялгаатай.⁴ Үүнд:

1. **Хуулийн 84.4-т заасан чиг үүргийг хэрэгжүүлээгүйгээс компанид учирсан хохирлыг шаардах эрх** – Энэ шаардлагыг ямар ч хувьцаа эзэмшигч хэрэгжүүлж болох хэдий ч гагцхүү 84.4 дэх хэсэгт заасан үүрэг зөрчигдсөн тохиолдолд ашиглана.
2. **Хуулийн 86.1-т заасан хохирлыг шаардах эрх** – Энэхүү шаардлагыг бусад бүхий л тохиолдолд ашиглах боломжтой гэж үзэж болох хэдий ч

⁴ Г.Давааням, Компани, арилжааны эрх зүйн тулгамдсан асуудлууд, 2020, 81 дэх тал. https://www.mse.mn/uploads/files/File/content/hugjliin_tuv/CompanyInformation/2.pdf

гагцхүү компанийн гаргасан хувьцааны нэг эсхүл түүнээс дээш хувьцаа эзэмшигч хэрэгжүүлэх боломжтой.

Хувьцаа эзэмшигч компанийг төлөөлөн түүнд учирсан хохирлыг нэхэмжлэх нь хуулийн этгээдийн хийсвэр шинжтэй нягт холбогдон тайлбарлагддаг. Хэдийгээр хуулийн этгээд нь иргэний эрх зүйн харилцаанд бие дааж оролцох, эрх эдэлж, үүрэг хүлээх чадвартай этгээд боловч түүнийг хэн нэгэн төлөөлж үйлдэл, эс үйлдэл хэрэгжүүлдэг. Хуульд зааснаар компанийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээд болох Гүйцэтгэх удирдлага, цаашлаад Төлөөлөн удирдах зөвлөл байх нь өөрсдөө компанид хохирол учруулах шийдвэр, үйл ажиллагаа явуулсан эсхүл гэм буруутай этгээдийн эсрэг компанийн эрх ашгийг хамгаалахдаа хойрго хандах тохиолдолд өөр хэн нэгэн этгээд нэхэмжлэл гаргах эрхийг эдэлнэ. Ийм компанитай хөрөнгийн хувьд нягт холбоотой хувьцаа эзэмшигч дээрх эрхийг эдлэх нь зүйтэй гэж үзэж холбогдох зохицуулалтыг хуульд тусгажээ. Түүнчлэн төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхийг урвуулан ашиглахаас сэргийлэх зохицуулалт дутмаг байна.

Нөгөө талаас дээрх нэхэмжлэл нь компанийн хувьцааны зонхилох хэсгийг эзэмшин шийдвэрт нөлөөлж чадах олонхын эсрэг жижиг хувьцаа эзэмшигчид өөрсдийн компани дахь эрх ашгийг хамгаалах хэрэгсэл болдог.⁵

Гэвч онолын хувьд, дээрх нэхэмжлэлийг гаргах үндэслэл нь компанийн эрх ашиг байдаг тул хувьцаа эзэмшигч компанийг төлөөлөн нэхэмжлэх эрхийг тусгахаас гадна түүнийг хэрэгжүүлэх үе шатыг мөн тусгах ёстой гэж зарим судлаачид үзэж байна.⁶ Тухайлбал, Япон болон АНУ-д хувьцаа эзэмшигч шүүхэд нэхэмжлэл гаргахаас өмнө эрх бүхий этгээдээс хохирлоо нэхэмжлэхийг компанид бичгээр мэдэгдэж шаардсан байх, ийнхүү шаардсанаас хойш хуульд заасан хугацаа өнгөрсний дараа шүүхэд нэхэмжлэл гаргах эрх нээгдэхээр зохицуулсан байна.⁷ Дээрх тохиолдолд компанийн удирдлагыг зүй ёсоор хэрэгжүүлэгч Төлөөлөн удирдах зөвлөлөөс шүүхэд нэхэмжлэл гаргахгүй байхаар шийдсэн үндэслэлийг нарийвчлан тайлбарлаж, хариу өгөх үүргийг хүлээнэ.

⁵ Б.Амарсанаа, Компанийн засаглал, Компанийн эрх зүйн тулгамдсан асуудал, 2012, 55 дахь тал.

⁶ Г.Давааням, Компанийн засаглал, Компанийн эрх зүйн тулгамдсан асуудал, 2012, 83 дахь тал.

⁷ Мөн тэнд, 83 дахь тал.

Үүнээс гадна, хувьцаа эзэмшигч компанийн эрх ашигт нөлөөлөх, нэр хүндийг унагаах зэрэг шударга бус зорилгоор дээрх төрлийн нэхэмжлэлийг гаргаж болох тул дээрх эрсдэлээс сэргийлэх зохицуулалтыг хуульд тусгах нь зүйтэй юм. Тухайлбал, эзэмшиж буй хувьцааны тоо, эзэмшсэн хугацаа зэрэгтэй холбоотой шаардлага тавих. 2011 оны Компанийн тухай хуульд 1 хувийн хувьцааны квотыг тусгасан байгаа хэдий ч эзэмшиж буй хугацааны хувьд шаардлага тавиагүй байна. Өөрөөр хэлбэл, аливаа этгээд компанийн дотоод хэрэгт оролцох зорилгоор компанийн хувьцааг олж аван, тэр даруй шүүхэд нэхэмжлэл гаргаж боломжтой байгаа юм.

Түүнчлэн компанийг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргахад практик дээр шүүхийн зардлын асуудал хөндөгддөг. Шүүхийн зардал гэдэгт шүүхээс хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдон зайлшгүй гарах зардлыг ойлгоно. Үүнд, Монгол Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн дагуу төлөх тэмдэгтийн хураамжаас гадна өмгөөллийн зардал хүртэл орох боломжтой. Хувьцаа эзэмшигч энэ төрлийн нэхэмжлэлийг шүүхэд гарган шийдвэрлүүлж, хохирлыг нөхөн төлүүлсэн тохиолдолд тухайн хувьцаа эзэмшигч биш компанид хохирлыг шилжүүлэх тул тухайн шийдвэрт ашиг сонирхолтой этгээд шүүхийн зардлыг хариуцах нь зүйтэй, цаашлаад улсын тэмдэгтийн хураамжийг нэхэмжлэлийн үнийн дүнгээс хамааран тогтоох бус тогтвортой дүнгээр төлдөг байхаар зохицуулах нь энэ төрлийн нэхэмжлэлийг гаргахад хөшүүрэг болох талаар хууль зүйн ухааны доктор Г.Давааням өөрийн бүтээлдээ тэмдэглэсэнийг анхааран үзүүштэй юм.⁸

Компанийг төлөөлөн нэхэмжлэл гаргах хувьцаа эзэмшигчийн эрхийг зүй зохистой хүрээнд хэрэгжүүлэх боломжийг тодорхой зохицуулах нь эдийн засагт урт хугацааны өгөөжтэйгөөс гадна төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан зүй бус шийдвэртэй тэмцэхэд чухал нөлөө үзүүлнэ. Гэвч ТУЗ шийдвэр гаргахдаа хянамгай байх үүргээ чандлан биелүүлсэн л бол хариуцлагаас чөлөөлөгдөх нь зарчимд нийцэх ёстойг анхаарах нь зүйтэй.

⁸ Мөн тэнд , 95 дахь тал.

3.2 Мөнгөн бус хөрөнгө оруулалт

Компанийг үүсгэн байгуулах, хөрөнгө оруулах, хувь нийлүүлэхтэй холбоотой харилцаанд тулгамдаж буй өөр нэгэн асуудал нь мөнгөн бус төлбөр, хөрөнгө оруулалттай холбоотой асуудал юм.

Техник, технологийн дэвшил хүчтэй мэдрэгдэж байгаа өнөө үед техник технологи, програм хангамж, барааны тэмдэг, оюуны бүтээл, туурвил, бизнесийн know-how зэрэг эдийн бус хөрөнгийн үнэ цэнийг хэрхэн тогтоох нь тодорхойгүй байх бөгөөд компанид мөнгөн бусаар хөрөнгө оруулах тохиолдолд тодорхойгүй байдлаас үүдэн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа удаашрах, зогсох, цаашлаад маргаан үүсэх зэрэг олон сөрөг үр дагавар үүсэж байна.

Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 3.1.1 дэх хэсэгт “хөрөнгө оруулалт” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулсан, санхүүгийн тайланд туссан биет болон биет бус хөрөнгийг гэж тодорхойлсон. Гэвч Компанийн тухай хуулийн 30 дугаар зүйлд хувь нийлүүлсэн хөрөнгийн талаар зохицуулсан боловч мөнгөн бус хөрөнгө оруулалттай холбоотой нарийн зохицуулалт тус хуульд байхгүй.

Мөн хуулийн 14.7 дахь хэсэгт “4.7.Үүсгэн байгуулагчид мөнгөн бус хэлбэрээр төлбөр хийх тохиолдолд эд хөрөнгийн үнийг компани үүсгэн байгуулах хуралд оролцогчид санал нэгтэй шийдвэрлэнэ” гэж зохицуулсан. Иргэний хуулийн дагуу эдийн бус хөрөнгө мөнгөн үнээр илэрхийлэгдэх, гүйлгээнд оролцох боломжтой. Практик дээр, бизнес эрхлэгчид өөрсдийн техник технологи, программ хангамж, барааны тэмдэг, бизнесийн know-how зэргийг гүйлгээнд оруулах сонирхол их байдаг боловч хэрхэн үнэлэх, хамгаалагдах асуудал тодорхой бус байдгаас гэрээ, хэлцлийн хэрэгжилт төдийлөн өндөр байдаггүй чиг хандлага байна. Техник технологийн шийдэл, програм хангамж, барааны тэмдэгт болон бусад оюуны өмчийг бүтээх явцад ихээхэн хэмжээний хүч хөдөлмөр, цаг хугацаа, хөрөнгө мөнгө зарцуулагддаг бөгөөд бизнесийн үйл ажиллагааг хөнгөвчлөх, ингэснээр санхүүгийн орлого, ашиг зэрэг эдийн засгийн үр өгөөжид ихээхэн нөлөө үзүүлдэг. Иймд дээрх эдийн бус хөрөнгөтэй холбоотой хөрөнгө оруулагчийн эрхийг хамгаалах нь зайлшгүй тавигдах асуудал мөн.

Оюуны өмчийн тухай хууль, Хөрөнгийн үнэлгээний тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид оюуны өмчийг ямар аргад суурилан үнэлэх талаар тодорхой зохицуулалтгүй. Гэсэн хэдий ч иргэний эрх зүйн гэрээний чөлөөт байдлын зарчмын дагуу талууд эдийн бус хөрөнгийн үнэлгээг харилцан тохиролцоо болон болгоомж байх бөгөөд практик дээр ийнхүү харилцан тохиролцдог хэдий ч техник, технологийн шийдэл, програм хангамжийн талаар мэдлэг мэдээлэлгүй этгээд хохирол амсах нь цөөнгүй. Эдийн бус хөрөнгийн үнэлгээг тогтооход өртөгт суурилсан, зах зээлийн ханшид суурилсан, орлогод суурилсан аргыг ашиглах нь элбэг. Энэ талаар судлаач С.Ганзоригийн “Барааны тэмдгийн эрх зүйн зохицуулалтад тулгамдаж буй зарим асуудал” сэдэвт өгүүллээс танилцах боломжтой.⁹

Цаашлаад мөнгөн бус хэлбэрээр буюу үл хөдлөх хөрөнгийг өмчлөх, ашиглах эрхийг шилжүүлэх замаар компанид хөрөнгө оруулж болох юм. Тухайлбал, хувьцаа эзэмшсэний оронд үнэ төлбөргүй ажлын байраар хангах гэх мэт. Үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэхэд улсын бүртгэлд бүртгүүлэх шаардлага үүсэх нь гарцаагүй ба хараахан хуулийн этгээдийн эрх зүйн чадвар олж аваагүй компанид өмчийг шилжүүлэх бүртгэл үүсэх боломжгүйг анхаарах нь зүйтэй.

Энэ мэт байдлаар компанид хувь нийлүүлэх тохиолдолд хувьцааны төлбөрийг хэрхэн төлөх, улсын бүртгэлд компанийг бүртгүүлэхэд талуудын онцгой тохиролцоог хүлээн зөвшөөрөх эсэх асуудал тодорхойгүй байгааг дурдах нь зүйтэй.

Иймд мөнгөн бус хэлбэрээр хөрөнгө оруулах тохиолдолд дээр дурдсан тодорхой бус асуудлыг даван туулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор, Компанийн тухай хуульд мөнгөн бус хөрөнгөөр хувь нийлүүлэхээр харилцан тохиролцсон бол мэргэжлийн үнэлгээчнээр үнэлүүлсэн байх шаардлага тавих, түүнчлэн улсын бүртгэлд бүртгүүлэхэд зарим төрлийн мөнгөн бус хөрөнгийг компанийн нэр дээрх түр дансанд шилжүүлээгүй байхыг хүлээн зөвшөөрөх, улсын бүртгэлд бүртгүүлж компани үүсгэн байгуулагдаж, эрх үүрэг хүлээх чадвартай болсон тохиолдолд хуульд заасан тодорхой хугацаанд мөнгөн бус хөрөнгийг шилжүүлэхийг үүрэг

⁹ С.Ганзориг, “Барааны тэмдгийн эрх зүйн зохицуулалтад тулгамдаж буй зарим асуудал”, 93 Хууль дээдлэх ёс №2, 2023.

болгох зэрэг нь бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих, түргэсгэхэд чухал ач холбогдолтой гэж үзэж байна. Жишээлбэл, Япон улсын Компанийн тухай хуулийн 445 – 452 дугаар зүйлд нээлттэй хувьцаат компанийн ногдол ашиг болон нөөц сан зэргийн холбоо хамаарал, харьцааг тодорхой зохицуулжээ.

Түүнчлэн нөөц сан бүрдүүлэх нь зээлдүүлэгч, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалахад мөн ач холбогдолтой байдаг байна.

3.3 Үүсгэн байгуулагчдын хуралтай холбоотой зохицуулалт

Монгол Улсад аж ахуй эрхлэх хамгийн түгээмэл хэлбэр нь компанийн хэлбэрээр зохион байгуулагдах бөгөөд цаашид нэмэгдэх хандлагатай байна. Бизнес регистрийн санд бүртгэлтэй хуулийн этгээдийн 78.4 хувийг компани дангаараа эзэлж буйг дараах зурагаас харж болно.

Зураг 1. 2022 оны Бизнес Регистрийн Санд бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын тоо /хариуцлагын хэлбэрээр/¹⁰




Үйл ажиллагаа явуулсан хуулийн этгээдийг ажиллагчдын тооны бүлгээр авч үзэхэд 1-9 ажиллагчидтай хуулийн этгээд 84.1 хувийг, 10-19 ажиллагчидтай хуулийн этгээд 7.4 хувийг, 20-49 ажиллагчидтай хуулийн этгээд 5.6 хувийг, 50 ба түүнээс дээш ажиллагчидтай хуулийн этгээд 3.0 хувийг тус тус эзэлж байна. 1-9 ажиллагчидтай хуулийн этгээдийн эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 0.9 нэгж хувиар өссөн байна.¹¹ Өөрөөр хэлбэл, Монгол Улсад жижиг, дунд бизнес эрхлэлт илүү

¹⁰ https://downloads.1212.mn/NJlhOdZrY-0GPa9tZzSK-Xx-IS6wqNstSp_NI-M9.pdf

¹¹ Мөн тэнд.

тархсан бөгөөд томоохон компанийн засаглал төдийлөн дэлгэрээгүй гэж хэлж болно.

Зураг 2. Үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийн ажиллагчдын тооны бүлэгт эзлэх хувь, жилийн эцэс бүрээр.



Эндээс дүгнэж үзвэл Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлж буй компанийн ихэнх нь харьцангуй жижиг бүтэцтэй байна. Цаашлаад үүсгэн байгуулагч нь хувьцаа эзэмшигч байх тохиолдол нэлээд түгээмэл байна.


Бүртгэлтэй хуулийн этгээдийн тоо өссөөр байгаа хэдий ч үйл ажиллагаа идэвхтэй явуулж буй байгууллагын тоо ч нэмэгдэж байгааг тэмдэглэх нь зүйтэй бөгөөд статистик тоон үзүүлэлтийг Зураг 2-оос үзнэ үү.

Статистикийн бизнес регистрийн санд бүртгэлтэй байгаа 246.4 мянган хуулийн этгээдийн 35.1 хувь нь үйл ажиллагаа явуулж, 64.9 хувь нь үйл ажиллагаа явуулаагүй байна. Үйл ажиллагаа явуулаагүй хуулийн этгээдийн 114.2 мянга буюу 71.4 хувь нь үйл ажиллагаа түр зогсоосон, 41.6 мянга буюу 26.0 хувь нь үйл ажиллагаа эхлээгүй, 4.2 мянга буюу 2.6 хувь нь бусад шалтгаантай байна.¹²

Зураг 2. Хуулийн этгээдийн тоо /үйл ажиллагаа эрхлэлтийн байдлаар/, 2022.¹³

¹² Мөн тэнд.

¹³ https://downloads.1212.mn/NJIhOdZrY-0GPa9tZzSK-Xx-IS6wqNstSp_NI-M9.pdf



Эндээс дүгнэж үзвэл, үүсгэн байгуулагдсан боловч үйл ажиллагаа эрхэлдэггүй хэлбэрийн төдий хуулийн этгээд /үүнд компани дийлэнх хувийг эзэлнэ/ олон байна. Ийнхүү үйл ажиллагаа явуулаагүй нь эдийн засгийн байдалтай шууд холбоотой байж болох ч өөр бусад шалтгаан ч мөн бий гэж үзэж болно. Тухайлбал, бизнесийн үйл ажиллагаа эрхлэх аливаа төсөөлөл, төлөвлөгөөгүй атлаа өөр бусад зорилгоор компани үүсгэн байгуулах гэх мэт. Цаашлаад, барааны тэмдгийн гэрчилгээ эзэмшигчийн эрхэд хууль бусаар халдах зорилгоор зориуд тухайн нэр бүхий хуулийн этгээдийг үүсгэн байгуулах тохиолдол ч мөн практикт бий.

Гэвч компани үйл ажиллагаа тогтвортой явуулахгүй байх нь эдийн засагт хэрхэн нөлөөлөх талаар шууд дүгнэлт өгөх боломжгүй ч үйл ажиллагааг анхнаас нь идэвхжүүлэх, түүнд дэмжлэг үзүүлэх зорилгоор компанийн үүсгэн байгуулагдах харилцааг тодорхой зохицуулах аргыг хэрэглэх боломжтой гэж харж байна. Гэсэн хэдий ч эрх зүйн зохицуулалтын өөрчлөлт нь эдийн засгийн харилцаанд шууд өөрчлөлт авчрахгүй гэдгийг анхаарах нь зүйтэй. Хууль тогтоомж нийгмийн харилцааг зохицуулах, шийдвэрлэх чиг үүргээс гадна шинэ ололт, дэвшил рүү шилжихэд нийгэмд түлхэц үзүүлэх ач холбогдолтой юм. Өөрөөр хэлбэл, компани үүсгэн байгуулахад хязгаарлалт тавихгүй ч компанийн үйл ажиллагааг цаашид үргэлжлүүлэх чиглэлд түлхэц үзүүлэх нь чухал. Ингэхдээ үүсгэн байгуулагч этгээдийн эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхой тусгах аргыг ашиглах боломжтой.

Компанийг үүсгэн байгуулах хоёр үндсэн арга байдаг. Нэгдүгээрт, үүсгэн байгуулагч бүх хувьцааг эзэмших замаар дангаараа байгуулах, хоёрдугаарт бусад

этгээдээс хөрөнгө татах замаар үүсгэн байгуулах. Хоёр дахь аргаар компани үүсгэн байгуулах тохиолдолд хувьцаа эзэмшигч болох хүсэлтэй этгээдэд мэдээлэл өгөх, судалгаа хийх, холбон зуучлахад зардал өндөр зарцуулах сул талтай байдаг байна. Гэсэн хэдий ч хувилбар бүрд хэрэглэгдэх уян хатан зохицуулалт хэзээд шаардлагатай.

2011 оны Компанийн тухай хуульд үүсгэн байгуулах хурлын талаар дараах зохицуулалт тусгагдсан. Үүнд:

14 дүгээр зүйл.Компани үүсгэн байгуулах хурал

14.1.Компани үүсгэн байгуулах хурлыг үүсгэн байгуулагчид зарлан хуралдуулна.

14.2.Компани үүсгэн байгуулагчид санал нэгтгэйгээр өөрөөр шийдвэрлээгүй бол үүсгэн байгуулагч бүр компани үүсгэн байгуулах хуралд саналын тэнцүү эрхтэй оролцоно.

14.3.Компани үүсгэн байгуулах хурлаар дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ:

14.3.1.компани байгуулах тухай;

14.3.2.компанийн дүрэм;

14.3.3.зарласан болон гаргах хувьцаа, тэдгээрээс үүсгэн байгуулагчдын худалдан авах үнэ;

14.3.4.төлөөлөн удирдах зөвлөлтэй байхаар шийдвэрлэсэн бол түүний гишүүдийг сонгох, тэдгээрийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;

14.3.5.компани үүсгэн байгуулахад гаргасан зардлыг нөхөн олгох журам;

14.3.6.компанид хувь нийлүүлэх хөрөнгийг бүрэн оруулж дуусах хугацаа.

14.4.Үүсгэн байгуулагчдын хооронд байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол бүх үүсгэн байгуулагч оролцсоноор компани үүсгэн байгуулах хурал хүчин төгөлдөр болох бөгөөд уг хуралд оролцогчдын дийлэнх олонхын саналаар шийдвэр гаргана.

14.5.Компани үүсгэн байгуулах хурлын даргыг үүсгэн байгуулагчдаас сонгоно.

14.6.Үүсгэн байгуулагчид мөнгөн бус хэлбэрээр төлбөр хийх тохиолдолд санал болгож байгаа эд хөрөнгийн үнийн талаар шаардлагатай гэж үзвэл үнэлгээний

байгууллага болон холбогдох мэргэжлийн шинжээчийн дүгнэлт гаргуулан санал боловсруулж, компани үүсгэн байгуулах хуралд оруулна.

14.7. Үүсгэн байгуулагчид мөнгөн бус хэлбэрээр төлбөр хийх тохиолдолд эд хөрөнгийн үнийг компани үүсгэн байгуулах хуралд оролцогчид санал нэгтэй шийдвэрлэнэ.

Хуулийн 14.1 дэх хэсэгт зааснаар компани үүсгэн байгуулах хурлыг үүсгэн байгуулагчид зарлан хуралдуулах үндсэн зохицуулалтыг тусгасан байна. Гэвч өмнө дурдсанаар үүсгэн байгуулагч хувьцааг бүрэн эзэмших замаар эсхүл захиалгын аргаар буюу бусад этгээдээс хөрөнгө татах замаар компани үүсгэн байгуулах зэрэг тохиолдлын аль алинд нь зэрэг хэрэглэгдэх боломжгүй.

Монгол Улсад ихэнх тохиолдолд үүсгэн байгуулагч хувьцааг эзэмших замаар компани байгуулдаг. Энэ тохиолдолд хуулийн этгээдийн нэрийг баталгаажуулж, үүсгэн байгуулах хурлыг хуралдуулж, Компани байгуулах тухай шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор компанийг улсын бүртгэлд бүртгүүлэхээр холбогдох баримт бичгийг бүртгэх байгууллагад өгч шийдвэрлэдэг. Улсын бүртгэлд бүртгүүлэхэд хувь нийлүүлсэн хөрөнгийг компанийн нэр дээрх түр дансанд байршуулсныг нотлох баримтыг гаргаж өгөх үүрэгтэй. Өөрөөр хэлбэл, компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийг үүсгэн байгуулах шийдвэр гаргаснаас хойш төлөх тохиолдол олон байна. Ийнхүү төлбөр төлөхөөс өмнө үүсгэн байгуулах хурал хуралдуулах нь компани үүсгэн байгуулах эхний аргатай зөрчилдөхгүй боловч хөрөнгө татан төвлөрүүлэх замаар компани байгуулах тохиолдолд хурлын шийдвэр хүчингүй болох үр дагаварт хүргэж болзошгүй. Өөрөөр хэлбэл, захиалга өгснөөс хойш санал болгосон хувьцааны үнэ буюу төлбөрийг төлсөн этгээд хувьцаа эзэмших эрхтэй болох бөгөөд үүний дараа үүсгэн байгуулах хуралд саналын эрхтэй оролцох нь зүйтэй.

Иймд компани үүсгэн байгуулах хурлыг хуралдуулахад тавигдах шаардлагыг ялгамжтай хуульчлан тогтоох нь практикт хүндрэл бэрхшээл учруулахаас зайлсхийнэ.

3.4 Үүсгэн байгуулах үеийн гэрээ хэлцэл, эрх бүхий албан тушаалтны бүрэн эрх

Компанийг үүсгэн байгуулагч, компанийн хувьцаа эзэмшигч хэмээх ойлголт нь зарим тохиолдолд давхацдаг боловч өөр ойлголт юм. Үүсгэн байгуулагч нь тухайн компанийн хувьцаа эзэмшигч байж болохын зэрэгцээ хувьцаа эзэмшихгүй ч байж болно.

Компанийн тухай хуульд үүсгэн байгуулагчийн талаар дараах зохицуулалтыг тусгажээ.

12 дугаар зүйл.Компанийн үүсгэн байгуулагч

12.1.Компанийн үүсгэн байгуулагч нь Монгол Улсын иргэн, хуулийн этгээд, хуульд заасан бол гадаад улсын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүн байж болно.

12.2.Компаниас гаргасан хувьцааг Монгол Улсын болон гадаад улсын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүн эзэмшиж болно.

12.3.Компани нэг үүсгэн байгуулагчтай байж болно.

12.4.Компанийн үүсгэн байгуулагч нь тухайн компанийн хувьцааг эзэмшихгүй байж болно.

12.5.Төр, түүний байгууллага нь дараах тохиолдолд компанийн үүсгэн байгуулагч болон түүний хувьцаа эзэмшигч байж болно:

12.5.1.төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрыг хувьчилснаар шинээр бий болсон компанийн;

12.5.2.төрийн өмчит үйлдвэрийн газрыг компанийн хэлбэрт оруулан өөрчлөн байгуулах замаар үүссэн төрийн өмчит компанийн;

12.5.3.хууль тогтоомжид заасан журмын дагуу дампуурч байгаа компанийн төрд төлөх өрийг хувьцаагаар нь сольж авсан компанийн (Энэ тохиолдолд төр тухайн хувьцааг гурван жилийн дотор бусад этгээдэд худалдах үүрэгтэй);

12.5.4.гадаад улсын хуулийн этгээдтэй хамтран байгуулсан компанийн;

12.5.5.хуульд заасан бусад.

12.6.Компанийг үүсгэн байгуулах, улсын бүртгэлд бүртгүүлэхтэй холбогдсон зардлыг компанийн үүсгэн байгуулагчид хамтран хариуцна.

12.7.Компани үүсгэн байгуулах хурлын буюу төлөөлөн удирдах зөвлөл /хэрэв нэг үүсгэн байгуулагчтай бол үүсгэн байгуулагч/-ийн шийдвэрээр энэ хуулийн 12.6-д заасан зардлыг компани хариуцаж болно.

12.8.Энэ хуулийн 12.6, 12.7-д заасны дагуу компанийг үүсгэн байгуулахтай холбогдсон зардлыг төлсөн этгээд нь бусад үүсгэн байгуулагч, түүний эзэмшиж байгаа болон эзэмшихээр захиалсан хувьцааны тоотой нь хувь тэнцүүлэн уг зардлыг нэхэмжлэн авах, эсхүл гаргасан зардлынхаа хэмжээнд хувьцаа эзэмших эрхтэй.

12.9.Компанийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч нь бусад компанийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч байж болно.

КтХ-ийн 12.4 дэх хэсэгт “Компанийн үүсгэн байгуулагч нь тухайн компанийн хувьцааг эзэмшихгүй байж болно” гэж заасан. Өмнө дурдсанаар, компанийг үүсгэн байгуулах 2 арга байгаа тул 2 дахь арга буюу хөрөнгө татан төвлөрүүлэх замаар компанийг үүсгэн байгуулах тохиолдолд үүсгэн байгуулагч харьцангуй үүрэг, хариуцлага хүлээж оролцох ёстой болдог. Тухайлбал, Япон Улсын Компанийн тухай хуульд захиалгын аргаар хувьцааг бусдад санал болгосон боловч захиалга бүрэн биелэгдээгүй эсхүл хувьцааны төлбөр төлөгдөөгүй бол үлдсэн бүх хувьцааг үүсгэн байгуулагчид худалдаж авах үүрэг хүлээх, компани байгуулагдаагүй эсхүл компанийг үүсгэн байгуулах хурлын шийдвэр хүчин төгөлдөр бус болсон тохиолдолд нэн даруй захиалагчид төлсөн хувьцааны төлбөрийг буцаан олгох зэрэг зохицуулалт бий.

Түүнчлэн компани үүсгэн байгуулагдахаас өмнө үүсгэн байгуулагчаас бусдын өмнө хүлээсэн өр, төлбөрийг хэрхэх асуудал хөндөгддөг. Тухайлбал, КтХ-ийн 12.6 дахь хэсэгт “Компанийг үүсгэн байгуулах, улсын бүртгэлд бүртгүүлэхтэй холбогдсон зардлыг компанийн үүсгэн байгуулагчид хамтран хариуцна.” гэж, мөн хуулийн 12.7 дахь хэсэгт “Компани үүсгэн байгуулах хурлын буюу төлөөлөн удирдах зөвлөл /хэрэв нэг үүсгэн байгуулагчтай бол үүсгэн байгуулагч/-ийн шийдвэрээр энэ хуулийн 12.6-д заасан зардлыг компани хариуцаж болно.” гэж,

хуулийн 12.8 дахь хэсэгт “Энэ хуулийн 12.6, 12.7-д заасны дагуу компанийг үүсгэн байгуулахтай холбогдсон зардлыг төлсөн этгээд нь бусад үүсгэн байгуулагч, түүний эзэмшиж байгаа болон эзэмшихээр захиалсан хувьцааны тоотой нь хувь тэнцүүлэн уг зардлыг нэхэмжлэн авах, эсхүл гаргасан зардлынхаа хэмжээнд хувьцаа эзэмших эрхтэй.” гэж тус тус заасан.

3.5 Компанийн нөөц хөрөнгөтэй холбоотой зохицуулалт

Монгол Улсад хэд хэдэн төрлийн санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг компанид нөөц хөрөнгө буюу нөөц сантай байх шаардлага тавигддаг. Тухайлбал, даатгалын компани, банк гэх мэт. Жишээлбэл, Даатгалын тухай хуульд зааснаар даатгагч нь гэрээний явцад үүссэн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор даатгалын нөөц сан бүрдүүлэх, даатгалын нөөц сангийн мөнгөн хөрөнгийг даатгалын багц дүрэмд зааснаас өөрөөр зарцуулахыг хориглодог. Иймд хуулиар шаардсанаас бусад тохиолдолд нөөц хөрөнгөтэй байх нь ховор.

КтХ-ийн 46.8 дахь хэсэгт ногдол ашгийг компанийн татвар төлсний дараах цэвэр ашгаас хуваарилахаар тусгасан. Цэвэр ашгаас нөөц санд хуваарилах талаар Компанийн тухай хуульд аливаа зохицуулалт байхгүй байна.

Илүү их хэмжээний ногдол ашиг өгөх нь хувьцааны үнийг өсгөх хандлагатай байдаг ч дахин хөрөнгө оруулалт хийх мөнгөн хөрөнгийн хэмжээ багасахад хүргэнэ. Тайлант хугацаанд ашигтай ажилласан ч дараагийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулах зорилгоор ногдол ашиг хуваарилахгүй байх нь бий. Гэвч ногдол ашиг хуваарилах болон хуваарилахгүй байх хоорондын тогтвортой харьцааг хангах нэг арга хэрэгсэл нь нөөц сан байгуулах арга байж болох юм.

Мөн түүнчлэн улс оронд нүүрлэж болох хямралын сөрөг нөлөөг хамгийн бага түвшинд хадгалах, ААН-үүдийн түвшинд хямралд бэлэн байж, тогтвортойгоор үйл ажиллагаагаа явуулах нөхцөлийг хангах үүднээс эрсдэлийн нөөц сан байгуулах нь ач холбогдолтой.¹⁴ Тухайлбал, 2020 оны 2 дугаар улирлын байдлаар Ковид-19 цар

¹⁴ Н.Нарантуяа нар, Шинэ Корона Вирус (Covid19)-ийн улмаас санхүүгийн салбарт үүсэх сөрөг нөлөөллийг бууруулахад хэрэгжүүлэх арга хэмжээ, 2020,

тахал нь ААН-үүдийн 45 хувьд нь маш ихээр, 28 хувьд нь дунд зэрэг, 15 хувьд нь бага зэрэг нөлөө үзүүлжээ. Энэ мэтчилэн эдийн засгийн хямралын үед тогтвортойгоор үйл ажиллагаа явуулах, цаашлаад компанийн үйл ажиллагааг тэлэхэд нөөц сангийн ач холбогдлыг ААН-үүд төдийлөн харгалзаж эхлээгүй байгаа юм. Ялангуяа нээлттэй хувьцаат компанийн тогтвортой байдал нь олон тооны хөрөнгө оруулагчид шууд нөлөө үзүүлдэг тул дэлхийн зарим улс оронд тайлант жилийн ашгаас нөөц сан бүрдүүлэх арга хэлбэр, хувь хэмжээг хүртэл тогтоосон байх ба нөөц сангаас ногдол ашиг хуваарилахыг хориглох нь цөөнгүй.

Зээлдүүлэгчийн хувьд компанид олгосон зээл нь баталгаатай эргэн төлөгдөх боломжтой байх нь юу юунаас чухал бөгөөд компанийн орлогоос хуваарилалт хийх нь зээлдүүлэгчийн дээрх ашиг сонирхлыг хөнддөг гол хүчин зүйлс юм. Компанийн ашиг орлогыг компанид үлдээх замаар компанийн зээл төлөх чадвар сайжирч байх нь зээлдүүлэгчийн ашиг сонирхолд нийцдэг бол харин компанид оруулсан өгөөжийг хүртэх нь хувьцаа эзэмшигчийн үндсэн эрх юм.

Компани нь дүрэмдээ тусгайлан заагаагүй бол бүх цэвэр ашгаа ногдол ашиг байдлаар тараах үүрэг хүлээдэггүй. Иймд ногдол ашиг тараах хуримтлалын хэмжээг нэмэгдүүлэх болон хорогдуулах аргыг ашиглах боломжтой. Тухайлбал, тусгай сан байгуулах замаар ногдол ашиг тараах хуримтлалын хэмжээг бууруулах нь хууль ёсны арга юм. Иймд дээрх хоёр ашиг сонирхлыг тэнцвэржүүлэхэд нөөц хөрөнгийн зохицуулалт чухал нөлөө үзүүлж болохоор байна.

3.6 Ногдол ашиг хуваарилахтай холбоотой зохицуулалт

Ногдол ашгийн бодлого гэж өнөө үед бэлэн мөнгөөр ногдол ашиг хүртээх буюу ирээдүй үед нэмэгдсэн хэмжээтэй ногдол ашиг тараах талаарх санхүүгийн бодлогыг хэлнэ. Ногдол ашиг хүртээх эсэх, хэр хэмжээтэй тараах нь ихэвчлэн компанийн зориулагдаагүй (чөлөөт) ашиг (бэлэн мөнгөний хэтрэлт)-ийн хэмжээгээр

тодорхойлогдох бөгөөд уг компанийн урт хугацаан дахь орлогын хүчин чадлаас шалтгаалдаг.¹⁵

Компанийн тухай хуулийн 3.3 дахь хэсэгт зааснаар хувьцаа эзэмшигчийн эрхийг энэ хууль болон компанийн дүрмээр тогтоох бөгөөд хувьцаа эзэмшигч нь ногдол ашиг авах, хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хэлэлцэж байгаа асуудлаар санал өгөх, компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх зэрэг үндсэн эрх эдэлнэ. Гэвч ногдол ашиг тарааж болохгүй нөхцөлийг хуулиар тодорхойлдог бөгөөд КтХ-ийн 47 дугаар зүйлд энэ талаар зохицуулсан байна.

КтХ-ийн 46.1 дэх хэсэгт зааснаар компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэрийг гаргах бөгөөд энэхүү шийдвэрийг 46.5 дахь хэсгийн дагуу санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор гаргасан байхыг шаарддаг. Гэтэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10.1 дэх хэсэгт зааснаар аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлангийн жил тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болох ба түүнээс 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах ёстой гэж үзвэл 02 сарын 19-ний өдрөөс өмнө Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр гарсан байх ёстой. Ногдол ашиг тараахад тавигдах үндсэн нөхцөлийг КтХ-ийн 47 дугаар зүйлээр зохицуулсан. Үүнд:

- ногдол ашиг төлсний дараа компани нь төлбөрийн чадвартай байх;
- ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь энэ хуулийн 30.5-д заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, түүний татан буулгалтын үнэ зэргийн нийлбэрээс их байх;
- компани нь эргүүлэн худалдаж авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх.

¹⁵ Г.Алтан-Очир, Ногдол ашиг авах тухай болон ногдол ашгийн талаарх бодлогын талаарх лавлагаа, мэдээлэл, 2016.

Гэтэл компанийн төлбөрийн чадварын үзүүлэлт, өөрийн хөрөнгийн хэмжээ зэрэг санхүүгийн үзүүлэлт нь жилийн эцсийн санхүүгийн тайлангаар тогтоогдох бөгөөд энэ тайланг аудитаар баталгаажуулж Төлөөлөн удирдах зөвлөл танилцах зэрэг үе шатууд дараа жилийн 4 дүгээр сар орчимд дуусдаг. Гэсэн хэдий ч уг шийдвэрийг хуулийн хугацаанд багтаан гаргасан компаниудыг үзвэл ихэвчлэн ногдол ашиг тараахгүйгээр шийдсэн байдаг бол, ногдол ашиг тараахаар шийдвэрлэсэн компаниудын шийдвэр хуулийн хугацаанаас хэтэрсэн байдаг. Энэхүү практик нь хуулийн 46.5 дахь хэсэгт заасан хугацааны шаардлагатай зөрчилддөг.

Иймд хуулийн 46.5 дахь хэсгийг бодит практикт нийцүүлж тогтоох, цаашлаад жилд нэг бус хэд хэдэн удаа ногдол ашиг хуваарилж болох боломжийг компанид олгож зохицуулах нь зүйтэй юм.

Практикт тулгамдаж буй дараагийн асуудал нь ногдол ашгийг хуваарилах шийдвэр гаргасан ч ногдол ашгийг хувьцаа эзэмшигчид шилжүүлэхгүй удаах явдал юм. “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д 2022 оны 12 сарын 31-ний байдлаар 183 ХК бүртгэлтэй байгаагаас 9% буюу 16 ХК нь 100 хувь төрийн өмчит, 5% буюу 11 ХК нь төрийн өмчийн оролцоотой, 86% буюу 156 ХК нь бүрэн хувьчлагдсан компани байна.

Доорх хүснэгтээс нээлттэй хувьцаат компанийн ногдол ашиг тараах шийдвэрийн огноо болон ногдол ашиг тараах огноог харьцуулан харах боломжтой.

№	Компанийн нэр	Сим-бол	Код	Шийдвэр огноо	Бүртгэх өдөр	Тараах өдөр	Нэгж хувьцаанд ногдох ашгийн хэмжээ	Нийт ногдол ашиг
1	Гутал ХК	GTL	88	8/2/2023	8/16/2023	2023/08/21-ний өдрөөс эхлэн	952.36	1,541,586,081.08
2	Гермес центр ХК	HRM	528	8/23/2023	9/13/2023	2023-10-20-ний дотор	12	942,516,012

3	Сүү ХК	SUU	135	8/16/2023	9/6/2023	2024-02-10- ний дотор	7.7	2,642,117,608.90
4	АПУ ХК	APU	90	8/9/2023	8/28/2023	2024-02-10- ний дотор	45	47,888,169,885.0
5	Таван толгой ХК	TTL	458	7/21/2023	3/21/2023	2023-08-01- ний өдрөөс	5530.8	291,280,688,160.
6	Богд Банк ХК	BOGD	558	7/7/2023	7/7/2023	2023/09/05- ний дотор	3,03	3,787,500,000
7	Тээвэр дархан ХК	TEE	217	2/18/2023	3/27/2023	2023/12/31- ний дотор	300	49,004,700
8	Таван толгой ХК	TTL	458	2/25/2023	3/21/2023	2023/04/29- ний өдрөөс	2743.8	144,502,775,760
9	Барилга корпораци ХК	BRC	476	2/18/2023	3/9/2023	2023/04/14- ний өдрөөс	500	20,331,000
10	Хөвсгөл хүнс ХК	HNS	431	2/17/2023	4/14/2023	2023/09/20- ны дотор	10	2,638,200
11	Талх чихэр ХК	TCK	22	2/16/2023	4/5/2023	2023/10/01- ний өдрөөс	350	358,296,050
12	Ган хийц ХК	GHC	234	2/17/2023	3/8/2023	2023/07/01- ний өдрөөс	100	24,246,400
13	Булигаар ХК	MBG	38	2/15/2023	3/31/2023	2023/09/01- ний өдрөөс	0.25	100,053,000
14	Түмэн шувуут ХК	TUM	549	2/11/2023	4/11/2023	2023/09/30- ны дотор	10.7	2,140,000,000
15	Хөвсгөл геологи ХК	HUV	108	2/17/2023	4/14/2023	2023/12/31- ний дотор	20	2,879,180
16	Ариг гал ХК	EER	191	2/18/2023	4/12/2023	2023/06/30- ны дотор	64.47	224,326,910
17	Техник импорт ХК	TEX	441	2/17/2023	3/9/2023	2023-04-14- ний өдрөөс	2000	128,976,131
18	Монгол шуудан ХК	MNP	541	2/15/2023	4/7/2023	2023-05-01- ний өдрөөс	2.26	225,641,500
19	Адуун чулуун ХК	ADL	461	3/16/2023	4/7/2023	2023-06-30- ны дотор	50	157,565,200
20	Махимпекс ХК	MMX	208	2/16/2023	4/4/2023	2023-10-01- нээс	100	380,072,100
21	Гермес центр ХК	HRM	528	2/15/2023	3/10/2023	4/15/2023	7.5	589,072,507.50

22	Төрийн Банк ХК	SBM	564	2/17/2023	4/10/2023	Эрх бүхий байгууллаг ын зөвшөөрөл ирснээс хойш 60 хоногийн дотор	63.68	48,084,529,200
23	Голомт Банк ХК	GLMT	562	2/15/2023	4/4/2023	Эрх бүхий байгууллаг ын зөвшөөрөл ирснээс хойш 60 хоногийн дотор	50	40,432,865,300
24	Богд Банк ХК	BOG D	558	2/8/2023	4/3/2023	Эрх бүхий байгууллаг ын зөвшөөрөл ирснээс хойш 60 хоногийн дотор	2.2193	2,774,099,391.71
25	Сүү ХК	SUU	135	2/17/2023	3/30/2023	2023/12/31- ний дотор	2.4	823,348,593.60
26	Улаанбаата р хивс ХК	UBH	7	2/16/2023	3/9/2023	2023/06/30- ны дотор	1570	635,581,530
27	Гутал ХК	GTL	88	2/15/2023	3/30/2023	2023/05/01- ний өдрөөс	1000	1,575,010,000
28	Инвескор ББСБ ХК	INV	553	2/17/2023	3/23/2023	2023/06/30- ны дотор	38	2,878,282,678
29	Э-Транс ложистикс ХК	ETR	537	2/17/2023	4/3/2023	2023-12-31- ний дотор	3	138,600,000
30	Хүрд ХК	HRD	8	2/17/2023	3/23/2023	2023 оны II улиралд	953.5	128,976,131
31	ЛэндМН ББСБ ХК	LEND	545	2/6/2023	3/24/2023	2023/04/30- ны дотор	1.75	1,293,778,000

32	Тахь-ко ХК	ТАН	44	2/17/2023	4/6/2023	2023/05/01- ний дотор	108	128,518,164
33	АПУ ХК	APU	90	2/13/2023	4/7/2023	2023/12/31- ний дотор	44	46,770,888,692
34	Дархан нэхий ХК	НЕН	71	2/17/2023	2/9/2023	2023/12/31- ний дотор	0.23	250,000,000
35	Баянгол зочид буудал ХК	BNG	13	2/15/2023	4/7/2023	9/1/2023	300	126,919,500
36	Материалим пекс ХК	MIE	379	2/14/2023	3/31/2023	2023-12-31- ний дотор	300	410,461,800
37	Монос хүнс ХК	MFC	551	2/8/2023	4/10/2023	2023-12-01- ний өдрөөс эхлэн	2.4	981,241,027.20
38	УБ-БҮК ХК	ВУК	195	2/15/2023	3/30/2023	2023-06-01- ний өдрөөс эхлэн	5	657,737,500
39	Монгол Базальт ХК	MBW	544	2/13/2023	3/31/2023	2023-12-31- ний дотор	20	1,128,340,000
40	Сэндли ББСБ ХК	SEND	561	2/6/2023	3/2/2023	2023-07-03- ны дотор	2.75	614,817,500
41	Тандэм инвэст ББСБ ХК	VIK	438	2/6/2023	3/2/2023	12/29/2023	1.32	1,990,714,055.56
42	Эрдэнэт Суврага ХК	SVR	377	1/12/2023	2/6/2023	2023-06-30- ны дотор	5	780,270

2023 онд ногдол ашиг тараасан 42 компанийг харьцуулбал, ногдол ашиг тараах шийдвэрийн огнооноос 1-3 сарын хугацааны дараа ногдол ашиг тараасан 9 компани, 4-10 сарын хугацааны дараа ногдол ашиг тараасан 33 компани байна. Үүнээс цөөнгүй компани ногдол ашиг тараах өдрөө тухайн оны эцсийн өдрөөр тогтоосон байгаа нь харагдаж байна. Иймд ногдол ашиг авах хувьцаа эзэмшигчийн үндсэн эрхийг хамгаалах үүднээс ногдол ашиг тарааж дууссан байх огноог хуульд тусгах нь ач холбогдолтой байж болох юм.

Ийнхүү ногдол ашиг тараах эцсийн огноог тогтоосон тохиолдолд хугацаа хэтрүүлсэн тохиолдолд алданги, эсхүл өөр хуулийн хариуцлага ногдуулах үндэслэл бүрдэх юм.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Компанийн тухай хуулийн хэрэгжилтийг судалж, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийлээ.

Компанийн жижиг хувьцаа эзэмшигчийн эрх ашгийн талаарх зохицуулалт

Компанийн эрх ашигт хохирол учруулах шийдвэр, үйл ажиллагаа явуулсан эрх бүхий албан хаагч, 20 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчийн эсрэг жижиг хувьцаа эзэмшигчийн хохирлыг барагдуулах зорилгоор нэхэмжлэл гаргах эрхийн зохицуулалт Компанийн тухай хуульд тусгагдсан. Гэсэн хэдий ч төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхийг урвуулан ашиглахаас сэргийлэх үүднээс нэхэмжлэгч хувьцаа эзэмшигчид хувьцааны квотын, хугацааны зэрэг шаардлага тавих чиг хандлага байгааг анхаарах нь зүйтэй.

Түүнчлэн компанийн дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх үүднээс дээр зааснаар шүүхэд нэхэмжлэл гаргахаас өмнө компанид энэ талаар мэдэгдэх, Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагад үндэслэл бүхий хариу өгөх боломж олгох, ийнхүү хариу өгөөгүй тохиолдолд нэхэмжлэл гаргах бусад процедур, шүүхийн зардлыг нөхөн төлүүлэх зэрэг зохицуулалт дутмаг байна.

Мөнгөн бус хөрөнгө оруулалт

Техник, технологийн хөгжил эдийн засгийн салбар бүрд чухал ач холбогдлоо үзүүлж буй өнөөгийн цаг үед бизнес эрхлэгчид өөрсдийн бүтээсэн тоног төхөөрөмж, технологийн шийдэл, програм хангамж, цаашлаад барааны тэмдэг, бүтээгдэхүүний загвар болон бусад эдийн засгийн үр өгөөж бүхий эдийн бус хөрөнгөөр эсхүл эд хөрөнгийн эрхээр хувь нийлүүлэх нь практикт цөөнгүй. Гэвч мөнгөн бус хөрөнгө оруулалтыг үнэлэх, түүнд ногдох хувьцааны тоог хэрхэн тооцоолох зэрэг тодорхой асуудлын улмаас компанийн үйл ажиллагаа эхлэхэд тодорхой хэмжээний саад үзүүлэх, цаашлаад компанийн үйл ажиллагааны явцад

мөнгөн бус хөрөнгө оруулалтын анхны үнэлгээ, эсхүл түүний үр өгөөж дээр дахин маргах зэрэг асуудал тулгарч байна. Иймд энэ төрлийн харилцааг тодорхой зохицуулах нь биет бус хөрөнгө, түүний эрхийг хамгаалах, цаашлаад биет бус хөрөнгийг эдийн засгийн эргэлтэд оруулахад чухал нөлөөтэй.

Үүсгэн байгуулагчийн хуралтай холбоотой зохицуулалт

Монгол Улсад үүсгэн байгуулагдаж буй ихэнх компанийн үүсгэн байгуулагч нь хувьцаа эзэмшигч байх хандлагатай байна. Гэвч үүсгэн байгуулагч нь өөрөө хувьцааг эзэмшихгүйгээс эсхүл түүний тодорхой хэсгийг эзэмшиж үлдсэн хэсгийг бусад этгээдэд санал болгон хөрөнгө төвлөрүүлэх замаар компанийг үүсгэн байгуулах тохиолдолд үүсгэн байгуулагчийн хүлээх үүрэг, хариуцлага төдийлөн тодорхой хуульчлагдаагүй байна. Иймд үүсгэн байгуулагчийн хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлох замаар хувь нийлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах нь зүйтэй.

Үүсгэн байгуулах үеийн гэрээ хэлцэл, эрх бүхий албан тушаалтны бүрэн эрх

Сүүлийн жилүүдэд үүсгэн байгуулагдаж буй хуулийн этгээдийн тоо нэмэгдсээр байгаа ч идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдийн дундаж тоо өсөхгүй, эсрэгээрээ үйл ажиллагаа нь зогссон хуулийн этгээдийн тоо ихэссэн дүр зураг байна. Энэхүү статистик үзүүлэлт нь бизнесийн үйл ажиллагаа явуулах аливаа зорилгогүйгээр, бусдыг төөрөгдүүлэх, аливаа ашигтай байдал олж авахаар хэлбэрийн төдий байдлаар компани үүсгэн байгуулах тохиолдлын тоотой холбоотой байж болзошгүй байна. Нөгөө талаас, компанийн үйл ажиллагаа хангалттай санхүүжилтгүйн улмаас үйл ажиллагаа зогсож байж болзошгүй.

Иймд үүсгэн байгуулагдаж буй компанийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах зорилгоор компанийг анх үүсгэн байгуулах үеийн харилцааг тодорхой зохицуулж, хөрөнгө татан төвлөрүүлэх замаар компани үүсгэн байгуулах хувилбарыг хуульд тодорхой тусгаж, үүнтэй холбоотойгоор хүлээх үүсгэн байгуулагч, эрх бүхий албан тушаалтны эрх, үүргийг нарийн зохицуулах шаардлага байна.

Компанийн нөөц хөрөнгөтэй холбоотой зохицуулалт

Монгол Улсад зохицуулалттай салбараас бусад салбарт үйл ажиллагаа явуулж буй компани нөөц сантай байх нь ховор байна. Нөөц эсхүл эрсдэлийн сан зэргийг байгуулах замаар мөнгөн хөрөнгийн хүрэлцээтэй байдлыг хангаж, төлбөрийн чадварын үзүүлэлт өндөр байх нь компанийн болон түүний хувьцааны үнэ цэнийг өсгөх, цаашлаад эдийн засгийн хямралыг бага хохиролтой даван туулах, үйл ажиллагааны цар хүрээг тэлэх зэрэг олон ач холбогдолтой тул компанийн зээлдүүлэгч, үйлчлүүлэгч, урт хугацааны хөрөнгө оруулагч зэргийг эрх ашиг нийцнэ. Иймд зохицуулалтгүй салбарт үйл ажиллагаагаа явуулж буй компани нөөц хөрөнгөтэй байж болох талаарх зохицуулалтыг хуульд тусгах нь бизнес эрхлэгчдийн шийдвэр гаргалтад нөлөө үзүүлнэ.

Ногдол ашиг хуваарилахтай холбоотой зохицуулалт

Ногдол ашиг хуваарилах бодлого нь компанийн зохион байгуулалтын хэлбэрээс хамаарч харилцан адилгүй байж болно. Ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргалтад хууль тогтоомжийн нөлөө харьцангуй бага хэдий ч нэгэнтээ ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн тохиолдолд ногдол ашиг тараах эцсийн хугацааг хуулиар тогтоох нь одоо үйлчилж буй хууль дахь алданги тооцох, хариуцлага тооцох зохицуулалтыг хэрэгжүүлэх урьдач нөхцөл болно.

ЭХ СУРВАЛЖ

А.ХУУЛЬ ТОГТООМЖ

1. Иргэний хууль.
2. Компанийн тухай хууль
3. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль
4. Даатгалын тухай хууль
5. Банкны тухай хууль.
6. Хөрөнгийн үнэлгээний тухай хууль.
7. Оюуны өмчийн тухай хууль.
8. Хөрөнгийн үнэлгээний тухай хууль.

Б.НОМ, СУРАХ БИЧИГ, ЭМХЭТГЭЛ

1. Хууль зүйн ухааны доктор, профессор Б.Амарсанаа “Компанийн засаглал, Компанийн эрх зүйн тулгамдсан асуудал”,
2. “Хууль зүйн ухааны доктор Г.Давааням “Компанийн эрх зүйн онол, практик”,
3. Г.Давааням, “Компани, арилжааны эрх зүйн тулгамдсан асуудал”, “Хувьцаат компанийн эрх зүйн үндсэн ойлголт”,
4. Г.Давааням, “Морал хазардын асуудлаас үүдэх толгой компанийн хариуцлага” ,
5. Б.Амарсанаа, Г.Давааням нарын “Арилжааны эрх зүй”
6. Д.Байлхүү, “Төлөөлөн удирдах зөвлөл”, Уб, Адмон, 2016.
7. Д.Байлхүү, “Хувьцаа эзэмшигчдийн хурал”, Уб, Адмон, 2016.
8. Д.Байлхүү, Г.Давааням, “Компанийн тухай хуулийн тайлбар”, Уб, 2023.

В.СУДАЛГААНЫ ТАЙЛАН, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ

1. Г.Алтан-Очир, Ногдол ашиг авах тухай болон ногдол ашгийн талаарх бодлогын талаарх лавлагаа, мэдээлэл, 2016.
2. А.Бодьбилэг, Хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хурлын талаар гомдол гаргах эрх болон түүний хязгаарлалт: Харьцуулсан судалгаа, 2022.

3. С.Ганзориг, “Барааны тэмдгийн эрх зүйн зохицуулалтад тулгамдаж буй зарим асуудал”, 93 Хууль дээдлэх ёс №2, 2023.
4. Н.Нарантуяа нар, Шинэ Корона Вирус (Covid19)-ийн улмаас санхүүгийн салбарт үүсэх сөрөг нөлөөллийг бууруулахад хэрэгжүүлэх арга хэмжээ, 2020,
5. Санхүүгийн зохицуулах хороо, <http://www.frc.mn/resource/frc/Document/2021/06/04/nbi0x8hg6p7cgp6c/Sudalgaanii%20tomhimol%202020.pdf>.
6. ХЗҮХ, “Компанийн эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал, тулгамдсан асуудал” сэдэвт судалгааны тайлан, 2020.
7. ХЗҮХ, “2011 оны Компанийн тухай хууль дахь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ” сэдэвт судалгааны тайлан, 2022.
8. ХЗҮХ, “Компанийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ” сэдэвт судалгааны тайлан, 2019.
9. ХЗҮХ, “Компани худалдан авах, өөрчлөн байгуулах үндсэн аргууд: гадаад орнуудын туршлага” сэдэвт судалгааны тайлан, 2013.
10. ХЗҮХ, Хязгаарлагдмал хариуцлагыг нэвтрүүлэх нь. Толгой болон охин компанийн хариуцлагын асуудал, 2010.
11. Ц.Золбоо, Хувьцаат компанийн эзэн ба агентын асуудал, түүнийг зохицуулах стратегиуд, Эрх зүй сэтгүүл №1, 2021.